

ТӨСӨЛ

Засгийн газрын 202.... оны дугаар
сарын -ны өдрийн дугаар
тогтоолын хоёрдугаар
хавсралт

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭГ ХЯНАХ БОЛОН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ:НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэ журмын зорилго нь Төр хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, түншлэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэйгээр хэрэгжүүлэхэд оршино.

1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7, 9 дүгээр зүйлд заасан төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.Энэ журам нь зөвхөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас (цаашид “Сангийн яам” гэх) зөвшөөрөл олгох, Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарах бөгөөд бусад хэлбэрээр зөвшөөрөл олгох харилцаанд үл хамаарна.

1.4.Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн (цаашид “түншлэл” гэх) бүрэн шинжилгээг хянаж зөвшөөрөл олгох, түншлэлийн гэрээ байгуулахад болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 29^{1.4}-т заасны дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн удирдлагын цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр хэрэгжүүлнэ.

1.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.

1.7.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тодорхойлж, тайлбарлана.

ХОЁР:ТӨСЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭГ ХЯНАЖ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

2.1.Сангийн яам нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.1.5-т заасны дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төсвийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл түүний хөрөнгийн эх үүсвэр болон түншлэлийн төрөл, төслийг хэрэгжүүлэх гэрээний төрөл, хэлбэрийг тодорхойлох зорилгоор төслийн бүрэн шинжилгээг хянана.

2.2.Энэ журмын 2.1-д зааснаар төслийн бүрэн шинжилгээг хянахдаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлд заасан шаардлага болон доор дурдсан нөхцөлийг хангасан эсэхийг хянана:

2.2.1.түншлэлийн төсөл хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан эсэх;

2.2.2.төслийн үр ашиг, ач холбогдол, хэрэгжүүлэх боломжийг тогтоосон дүгнэлт байгаа эсэх;

2.2.3.төслийн баг хэлэлцэж шийдвэр гаргасан байдал, хүчинтэйд тооцох боломжтой эсэх;

2.2.4.төслийн эрсдэлийг үнэлсэн эсэх, эрсдэлийг бууруулах дүгнэлт, төлөвлөгөө байгаа эсэх;

2.2.5.төслөөр хэрэгжүүлэх гэрээний хэлбэрийг бодитой тодорхойлсон эсэх;

2.2.6.төрөөс үзүүлэх дэмжлэг, баталгааг тодорхойлсон байдал.

2.3.Сангийн яам төслийн бүрэн шинжилгээг хянахдаа хавсралтаар баталсан хяналтын хуудасны дагуу хянана.

2.4.Сангийн яам нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон энэ журамд заасны дагуу төслийн бүрэн шинжилгээг хянасны дараа шаардлага хангасан төсөлд Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн өдрөөс хойш ажлын 15 өдөрт багтаан зөвшөөрөл олгоно.

2.5.Сангийн яам нь түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг хянаж, зөвшөөрлийг батлагдсан маягтын дагуу төлөвлөж, хяналтын хуудасны хамт цахимаар болон албан бичгээр түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.6.Сангийн яам нь түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг хянасан талаарх мэдээллийг нийтэд ил тод, нээлттэйгээр мэдээллийн цахим сүлжээгээр мэдээлнэ.

2.7.Төр хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хянахдаа энэ журмын 2.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

2.7.1.Түншлэлээр шинээр хэрэгжүүлэх дэд бүтэц, үйлчилгээнд хамаарах төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байх;

2.7.2.эрх бүхий байгууллагаас газрын зөвшөөрөл, тусгай болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

2.7.3.төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх), техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа; (цаашид “ТЭЗУС” гэх)

2.7.4.холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;

2.7.5.ТЭЗУС, ТЭЗҮ боловсруулах төсөл нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн, тухайн байгууллага, эсхүл салбарын зорилт болон дунд хугацааны төлөвлөлтөд нийцсэн, эрэлт хэрэгцээ, бодит шаардлагад тулгуурласан байх.

2.8.Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээнд зөвшөөрөл авахад дараах баримт бичгийг бүрдүүлэх бөгөөд эх хувь болох баримт бичгийг цаасаар, бусад баримт бичгийг цахим системээр ирүүлнэ:

2.8.1.зөвшөөрөл хүссэн албан бичгийн эх хувь;

2.8.2.төслийн гэрээний төсөл;

2.8.3.түншлэлийн төслийн урьдчилсан дүгнэлт;

2.8.4.түншлэгч этгээдээр гадаадын хуулийн этгээд оролцохоор бол холбогдох шийдвэр;

2.8.5.үл хөдлөх хөрөнгийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээг хувийн хэвшлийн түншлэгч байгууллагын өмчлөлд шилжүүлсэн баримт бичиг;

2.8.6.түншлэлийн төслийн багийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтойг тодорхойлсон дүгнэлт;

2.8.7.түншлэлийн төслийн мэдээлэл, танилцуулга, төслийн нийт өртөг, ашиглалтын хугацаа, хэрэгжилтийн хуваарь;

2.8.8.төслийн эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийг хуваарилах санал;

2.8.9.төслийн хэрэгжүүлэгч төрийн түншлэгч байгууллагын мэдээлэл, дэмжлэг үзүүлэхэд шаардагдах төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрлийн талаарх мэдээлэл.

ГУРАВ:ТҮНШЛЭЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭГ ХЯНАЖ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ, БУЦААХ

3.1.Сангийн яам түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн түншлэлийн бүрэн шинжилгээг хянасны дараа Төр, хувийн

хэвшлийн түншлэлийн тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл зөвшөөрөл олгохоос татгалзана.

3.2.Энэ журмын 3.1-д зааснаар татгалзах тохиолдолд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон энэ журмын холбогдох шаардлага хангахгүй байгаа хэсэг, заалтыг үндэслэнэ.

3.3.Татгалзсан шийдвэрийг хяналтын хуудасны хамт төслийн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээнд зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тухайн төслийг дахин авч хэлэлцэхгүй.

3.5.Татгалзсан төслийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

3.6.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг хянасны үр дүнд зарим асуудлыг тодруулах, нэмэлт мэдээлэл, баримт материал шаардлагатай тохиолдолд ажлын 15 өдөр хүртэл хугацаагаар сунгаж залруулга хийлгэхээр буцааж болно.

3.7.Сангийн яамнаас шаардсан нэмэлт мэдээлэл, тодруулга баримт бичгийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзана. Хэрэв Сангийн яамнаас шаардсан нэмэлт мэдээлэл, тодруулга баримт бичгийг тогтоосон хугацаанд ирүүлсэн бол түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг дахин хянана.

3.8.Нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан Сангийн яам зөвшөөрөл олгох, эсхүл олгохоос татгалзах аль нэг шийдвэрийг гаргаж түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.9.Түншлэлийн төлөвлөлтөд энэ журамд заасныг мөрдөөгүй, шаардлагатай баримт бичгийн иж бүрдэл, мэдээллийг албан бичгээр болон цахим системээр ирүүлээгүй тохиолдол нь түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг хянахаас татгалзах үндэслэл болно.

ДӨРӨВ:ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

4.1.Сангийн яам нь түншлэлийн төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн түншлэлийн гэрээний хүрээнд төсвийн эрсдэл, санхүүгийн чадавхын асуудал болон Засгийн газрын өрийн хэмжээнд үзүүлэх нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргана.

4.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.1.5-д заасны дагуу Сангийн яам нь түншлэлийн гэрээний төсөлтэй танилцан төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн тооцоо, шинжилгээг хянана.

4.3.Түншлэлийн төслийн түншлэгч нь түншлэлийн гэрээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан загвараар гүйцэтгэгчтэй байгуулах бөгөөд уг гэрээг байгуулснаас хойш

ажлын 5 өдөрт багтаан цахим системийн гэрээний удирдлага хэсэгт бүртгэж, гэрээний баталгаажуулалтыг хийнэ.

4.4.Энэ журмын 4.3-т заасан баталгаажуулалтын зохицуулалтыг энэ журам болон цахим системийн гарын авлагад заасны дагуу түншлэлийн гэрээний талууд хэрэгжүүлнэ.

4.5.Түншлэлийн гэрээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан шаардлагуудаас гадна тухайн төслийг хэрэгжүүлэх үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийг хавсарган иж бүрэн байгуулна.

4.6.Гэрээний хугацааг түншлэлээр хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэх нийт хугацааг харгалзан гэрээнд тусгана.

4.7.Гэрээний дугаар нь тухайн төслийн код байх бөгөөд багцаас хуваарилсан гэрээний хувьд цахим системээс авсан төслийн код байна.

4.8.Гэрээг цахим системд бүртгүүлснээр гэрээний мэдээллүүд олон нийтэд ил тод, нээлттэй байх бөгөөд гэрээг ил болгох эсэхэд тохируулна.

4.9.Түншлэлийн гэрээ дуусгавар болох, гэрээнд өөрчлөлт оруулахад гэрээ дүгнэсэн актыг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу гаргаж хавсаргана.

4.10.Гэрээний алдангийн хувь хэмжээ, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд тусгах бөгөөд алданги үүссэн тохиолдолд энэ талаар гэрээ дүгнэсэн актад тусгана.

4.11.Хяналтын хуудас бүрэн бөглөгдөх боломжгүй, түншлэлийн гэрээний баримт бичгийн иж бүрдэл дутуу, шаардлага хангахгүй, тэдгээрт тусгагдсан асуудал холбогдох хууль тогтоомжид нийцээгүй бол Сангийн яам нь түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн баримт бичгийг ажлын 10 өдрийн дотор цахим системээр болон албан бичгээр буцаана.

4.12.Түншлэлийн гэрээнд зөвшөөрөл олгоход доор дурдсан баримт бичгийн иж бүрдлийг хангасан байна:

4.12.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон Засгийн газрын баталсан холбогдох журмаар түншлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай холбогдох байгууллагын шийдвэр дүгнэлт, хурлын тэмдэглэл;

4.12.2.түншлэлийн гэрээнд заасан уг гэрээг хүчин төгөлдөрт тооцох нөхцөлүүд хангагдсан эсэх талаарх дүгнэлт;

4.12.3.түншлэлтэй холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн дагуу хөндлөнгийн байгууллагын дүгнэлт, зөвлөмж болон тухайн төсөл, арга хэмжээтэй холбогдон гарсан дүгнэлт, зөвлөмжийн дагуу шаардлагатай баримт бичиг;

4.12.4.түншлэлийн гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын шийдвэрийн төсөл;

4.12.5.түншлэгчдийн хооронд байгуулах төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний төсөл,

4.13.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг энэ журмын хавсралтаар баталсан хяналтын хуудсаар тодорхойлно.

4.14.Сангийн яам нь түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгохдоо Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн энэ журмын хавсралтад заасан хяналтын хуудсыг хөтөлнө.

4.15.Энэ журмын 4.13-т заасан баримт бичгийн бүрдлийн үнэн зөв эсэхийг төслийн гэрээний тал бүрэн хариуцна.

4.16. Сангийн яам нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 26.4 дэх хэсэг болон энэ журамд заасны дагуу сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээний дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн дүгнэлт, төслийн баримт бичгийг хянасны дараа шаардлага хангасан төсөлд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

4.17.Сангийн яам нь түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгохдоо батлагдсан маягтын дагуу үйлдсэн албан бичгийг хяналтын хуудасны хамт цахимаар болон албан бичгээр түншлэлийн асуудал эрхлэх төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.18.Сангийн яам нь түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг нийтэд ил тод, нээлттэйгээр мэдээллийн цахим сүлжээгээр мэдээлнэ.

4.19.Түншлэлийн гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

ТАВ:ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

5.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.1.5-д заасны дагуу Сангийн яам нь түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл өгөх, зөвшөөрөхгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.2.Сангийн яамны зөвшөөрөлд үндэслэн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналаар дараах тохиолдолд түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ:

5.2.1.түншлэлийн гэрээний агуулгын ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулснаас хойш бүхэлдээ, мэдэгдэхүйц өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй болох нь

тогтоогдсон бөгөөд талуудаас түншлэлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан;

5.2.2.гэнэтийн болон давагдашгүй, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлын улмаас төслийн техникийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын тохиролцсон нийт хэмжээ өөрчлөгдсөн, хуульд зааснаар нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн тайланд өөрчлөлт орсон, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс бий болсон бөгөөд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар талууд харилцан тохиролцсон түншлэлийн гэрээнд заасан хугацаа, нөхцөлд үндэслэн гэрээний зүйлийн түншлэлийн зүйлийн эрхийг хувийн хэвшлийн түншлэгчид олгох;

5.2.3.төрийн түншлэгчээс түншлэлийн гэрээний хамрах хүрээг өргөжүүлэн анхны гэрээнд тусгаагүй боловч зайлшгүй шаардлагатай ажил үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгчээр нэмэлтээр хийлгэх шаардлагатай болсон.

5.3.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн тооцоо, шинжилгээг хянана.

5.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 39.3-т заасны дагуу түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь анх тохирсон гэрээний үнийн дүнг 15-аас дээш хувиар өсгөхөөр, эсхүл анхны гэрээнд заагаагүй ажил үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгч нэмэлтээр үзүүлэх үр дагавартай бол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх талаар Сангийн яамны зөвшөөрлийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

5.5.Түншлэлийн гэрээнд, нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох эсэхэд энэ журамд заасан зохицуулалтууд нэгэн адил мөрдөгдөнө.

ЗУРГАА:ТҮНШЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1.Сангийн яам нь түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.түншлэлээр хэрэгжүүлэх бүрэн шинжилгээг энэ журамд зааснаар хүлээн авах, хянах, зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах, буцаахтай холбоотой удирдлагыг хэрэгжүүлэх;

6.1.2.санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргах;

6.1.3.түншлэлийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

6.1.4.шаардлагатай баримт бичиг, мэдээллийг төрийн байгууллага, хувийн түншлэгч, холбогдох бусад этгээдээс гаргуулж авах;

6.1.5.түншлэлээр хэрэгжүүлж байгаа болон түншлэлээр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй танилцах, үнэлэх, түншлэлийн үр ашиг, ач холбогдол, үр дүнг тооцох чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллах, энэ хүрээнд аргачлал, үнэлгээний арга зүйг боловсруулж, хэрэгжүүлэх;

6.1.6.түншлэлээр санхүүжүүлсэн төслийн өмчийн удирдлага, ашиглалтыг хянах;

6.1.7.цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах;

6.1.8.түншлэлийн чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, чадавхжуулах арга хэмжээг хариуцах;

6.1.9.түншлэлийн удирдлагыг сайжруулах чиглэлээр төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл болон бусад холбогдох байгууллагын түншлэлийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.2.Түншлэлийн асуудал эрхлэх төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.1.түншлэлийн саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр сонгон шалгаруулж, эрэмбэлэх, төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тогтоох;

6.2.2.төслийн саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн түншлэлээр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

6.2.3.тухайн жилд хэрэгжүүлэх түншлэлийн саналыг Сангийн яаманд хүргүүлэх;

6.2.4.энэ журмын хүрээнд гарсан аргачлал, заавар, гарын авлагыг батлан үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах;

6.2.5.түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, бүрэн хариуцах;

6.2.6.түншлэлийн чиглэлээр тухайн салбарын судалгаа, дүн шинжилгээ хийх, танилцуулга, мэдээлэл бэлтгэх;

6.2.7.түншлэлийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, тайлагналтыг цахим системээр дамжуулан гүйцэтгэх, хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах;

6.2.8.түншлэлээр хэрэгжүүлж байгаа болон төсвөөс санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмчийн бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх;

6.2.9.түншлэлийн тайлан, үр дүн, үр ашгийг тооцох, мэдээллийн сан бүрдүүлэх;

6.2.10.тухайн жилийн батлагдсан түншлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

6.2.11.түншлэлийн төлөвлөлт, хяналт, тайлагналтын үе шатуудад холбогдох мэдээлэл, баримт материалын иж бүрдлийг цахим системд оруулж, албан бичгээр баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлэх бөгөөд тэдгээрийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хариуцах.

6.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.3.1.тухайн орон нутагт хэрэгжүүлэх түншлэлийн төслийн саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх;

6.3.2.тухайн жилд хэрэгжүүлэх түншлэлийн саналыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

6.3.3.түншлэлийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

6.3.4.энэ журмын хүрээнд гарсан цахим систем, аргачлал, заавар, гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах;

6.3.5.түншлэлийн чиглэлээр тухайн орон нутгийн судалгаа, дүн шинжилгээ хийх, танилцуулга, мэдээлэл бэлтгэх;

6.3.6.түншлэлийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цахим системээр дамжуулан гүйцэтгэх, хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах;

6.3.7.түншлэлийн тайлан, үр дүн, үр ашгийг тооцох, мэдээллийн сан бүрдүүлэх;

6.3.8.түншлэлээр хэрэгжүүлж байгаа төслийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн бүрэн, үнэн зөв бүрдүүлэх.

ДОЛОО:ТҮНШЛЭЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭНД БОЛОН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1.Цахим системийн удирдлага, зохион байгуулалт:

7.1.1.түншлэлийн бүрэн шинжилгээг хянаж зөвшөөрөл олгох, түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох

үйл ажиллагааны цахим системийн бүтэц, схем, загварчлал болон үйл ажиллагаа нь оюуны өмчид бүртгэгдсэн байх бөгөөд Сангийн яам хариуцан зохион байгуулна.

7.1.2.түншлэлийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмчийн удирдлага, ашиглалтын үйл ажиллагааг цахим системийн хэрэглэгчийн холбогдох эрх авснаар хэрэгжүүлнэ;

7.1.3.цахим системийн хэрэглэгчийн эрх нь үндсэн админ, админ, удирдлага, мэргэжилтэн, хянагч админ, гүйцэтгэгч гэсэн ангилалтай байх бөгөөд ангилал тус бүрийн хэрэглэгчийн эрх нь дараах байдлаар олгоно;

7.1.3.а.цахим системийн “үндсэн админ” эрхтэй хэрэглэгч нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан нэгж байх бөгөөд өөр этгээдэд олгохгүй;

7.1.3.б.цахим системийн хэрэглэгчийн “админ” эрхийг холбогдох этгээдэд олгох асуудлыг энэ журмын 7.1.3.а-д заасан үндсэн админ эрхтэй хэрэглэгч хариуцан шийдвэрлэх бөгөөд тухайн этгээдийн албан бичгээр ирүүлсэн хүсэлтэд үндэслэнэ;

7.1.3.в.тухайн байгууллагын “админ” эрхтэй хэрэглэгч нь орон нутаг, салбар, харьяа байгууллага болон өөрийн байгууллага дотор ашиглах “удирдлага”, “хянагч админ”, “мэргэжилтэн” гэсэн ангиллын хэрэглэгчийн эрхийг төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан чиг үүргийн дагуу олгоно;

7.1.3.г.цахим системийн “хянагч админ” хэрэглэгч нь захиалагчийн техник, технологийн хяналтын холбогдох мэргэжилтэнд хяналтын хэрэглэгчийн эрхийг олгоно;

7.1.3.д.цахим системийн хэрэглэгчийн “гүйцэтгэгч” эрх нь захиалагч энэ журамд заасны дагуу тухайн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээг цахим системд бүртгэснээр гүйцэтгэгчид олгогдоно.

7.1.4.цахим системийн хэрэглэгчийн холбогдох эрхийг төр хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаанд хамааралгүй этгээдэд олгохгүй, бусдад дамжуулж ашиглуулахгүй бөгөөд хэрэглэгчийн эрхтэй холбоотой цахим системийн аливаа асуудал, зөрчилд тухайн хэрэглэгч бүрэн хариуцлага хүлээнэ;

7.1.5.цахим системийн хэрэглэгч нь энэ журамд заасны дагуу цахим системд холбогдох мэдээллийг оруулах, бүртгэх, баталгаажуулах, илгээхдээ цахим системийн гарын авлагад заасны дагуу гүйцэтгэх бөгөөд мэдээллийн бүрдэл болон түүний үнэн зөв байдлыг бүрэн хариуцаж, өөрийн эрхэд хамаарах цахим систем дэх мэдээллийг бусдад задруулах, дамжуулах, албан бус байдлаар зөвшөөрөлгүй ашиглахгүй байх үүрэг хүлээнэ.

7.2.Ил тод, нээлттэй байдал:

7.2.1.Төрийн болон албаны нууцад хамаарах түншлэлийн төслөөс бусад төр, хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаа, мэдээлэл, тайлагналт нь ил тод, нээлттэй байна;

7.2.2.Цахим системийн мэдээллийг олон нийтэд зориулсан www.publicinvestment.gov.mn цахим хуудаст байршуулах бөгөөд андройд болон iOS үйлдлийн системд ажиллах боломжтой “төр хувийн хэвшлийн түншлэл” болон “publicinvestment” нэр бүхий аппликейшнаар дамжуулан мэдээллийг олон нийтэд ил тод хүргэнэ.

НАЙМ:БУСАД ЗҮЙЛ

8.1.Энэ журамд заасныг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн албан хаагч нь чиг үүргээ төрийн албаны мэргэжлийн ёс зүйг баримтлан, хууль ёсны дагуу, ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус, бие даан гүйцэтгэх ба тухайн этгээдийн хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

8.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас цахим систем ажиллах боломжгүй болсон тохиолдолд баримт бичиг хүлээн авах хугацааг хойшлуулж, захиалагчид энэ тухай мэдэгдэнэ.

8.3.Түншлэлийн төслийн жагсаалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мэдээллийг www.iltod.mof.gov.mn, <https://mof.gov.mn>, www.publicinvestment.gov.mn цахим хуудаст тухай бүр мэдээлнэ.

8.4.Энэ журамд заасан баримт бичгийг архивд өгөөгүй тохиолдолд холбогдох хариуцлагыг тухайн асуудал хариуцсан албан тушаалтан хүлээнэ.

8.5.Гэрээний талууд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

8.6.Сангийн яам нь төр болон хувийн хэвшил хоорондын үр дүнтэй, тогтвортой түншлэлийг хөгжүүлэхэд төсвийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл, хөрөнгийн эх үүсвэр талаас нь хянаж, гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохдоо тооцоо, судалгаанд үндэслэсэн, нээлттэй, ил тод байна.

8.7.Түншлэлийн төслийн бүх үе шатанд төсөл хэрэгжүүлэхэд төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийг тооцсон байна.

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дугаар	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Баг, хороо	Хувийн хэвшлийн түншлэгчийн хаяг, байршил, удирдлагын мэдээлэл	Төрийн түншлэгчийн мэдээлэл	Аймаг, нийслэл оноо	Төслийн багийн оноо	Ажлын хэсгийн оноо	Салбар	Дэд салбар	Гэрээний төрөл	Хүчин чадал	Хэмжих нэгж	Хугацаа	
														Эхлэх	Дуусах
1.															

Төслийн тухайн жилд батлагдсан төсөв /сая төгрөг/	Түншлэлийн нийт өртөг /сая төг/	Нийт авсан санхүүжилт /сая төг/	Түшлэхийн төсөлд тусгах төсөвт өртөг /байгууллагын санал/, сая төгрөг	Тухайн онд санхүүжих дүн /байгууллагын санал/, сая төгрөг <i>3 хүртэлх жилээр</i>
Тухайн төсөл хэрэгжиж эхэлсэн оноос төлөвлөж буй он хүртэлх жил бүрийн батлагдсан төсөвт өртөг	Тухайн төсөл хэрэгжиж эхэлсэн оноос төлөвлөж буй он хүртэлх жил бүрийн санхүүжсэн дүн			

Аргачлалын дагуу холбогдох мэдээлэл байгаа эсэх						Ажлын явц хувь /шилжих төслийн хувьд/	Гүйцэтгэгч компани /шилжих төслийн хувьд/	Түншлэлийн мэдээлэл /шилжих төслийн хувьд/			Төслийн код /цахим системээс/	Дэлгэрэнгүй тайлбар
Төслийн бүрэн шинжилгээ хийгдсэн эсэх	Бодлогын баримт бичигт тусгагдсан эсэх	Түншлэлийн өртөг	ТЭЗҮ холбосон эсэх /системд/	Газрын зөвшөөрөл	Оноо өгөгдсөн эсэх			Сонгон шалгаруулалт зарласан огноо	Гэрээ байгуулсан огноо	Сонгон шалгаруулалт зарлаагүй төсөл		

*-Жил бүр Төсвийн төсөл боловсруулах удирдамжийн хамт Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх маягт, үүний дагуу албан бичгээр болон дээрх хүснэгтийн мэдээллийг цахим системд оруулна.

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Түншлэлийн төслийн нэр, хүчин чадал, байршил.....

Гэрээний дугаар.....

Хувийн хэвшлийн түншлэгчийн нэр

№	Шалгуур үзүүлэлт, шаардлага	Тийм	Үгүй
1.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн төслийн нэр нь хуулиар батлагдсан нэр томъёотой тохирч байгаа эсэх		
2.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулсан эсэх		
3.	Төслийн баримт бичиг нь холбогдох хууль, энэ журмын шаардлагыг хангасан эсэх		
4.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн цахим системд бүртгэгдсэн эсэх		
5.	Түншлэлийн төслийн төрөл тодорхой эсэх		
6.	Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх		
7.	Урьдчилгаа авах тохиолдолд энэ журамд заасан бусад баримт бичгийг бүрэн ирүүлсэн эсэх		
8.	Түншлэлийн төслийн танилцуулга, төслийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, жишиг маягт, төсөл хэрэгжүүлэх төрийн түншлэгчийн талаарх мэдээлэл, тайлбар		
9.	Түншлэлийн төслийн гол хүчин зүйл, хувийн хэвшлийн түншлэгчийн үзүүлэх үйлчилгээ, төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл		
10.	Төслийн бүрэн шинжилгээг энэ журамд заасан маягтын дагуу ирүүлсэн эсэх		
11.	Төслийн хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн түншлэгчийн санхүү, удирдлага, хүний нөөцийн чадавх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага		
12.	Төслийн гэрээний хавсралт болох хэрэгжилтийн хуваарьтай нийцсэн эсэх		
13.	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт хуульд заасан зориулалттай нийцсэн эсэх		
14.	Барилга угсралтын болон их засварын ажил нь хувийн, эсхүл өмчийн бусад хэлбэрийн этгээдийн өмчлөлийн зүйлд хийгдээгүй байх		

Тайлбар:

“Тийм/Үгүй” гэсэн баганад “Тийм”, эсхүл “Үгүй” гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.

ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/

ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:...../Нэр, Гарын үсэг/
огноо

Хавсралт 4

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ /ТХХТ/-ИЙН ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүчин чадал, байршил.....
Гэрээний дугаар.....
Гүйцэтгэгчийн нэр

№	Шалгуур үзүүлэлт, шаардлага	Тийм	Үгүй
1.	Төрийн өмчийн төр хувийн хэвшлийн түншлэлийн зүйлийн жагсаалтад тусгагдсан эсэх		
2.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томъёотой тохирч байгаа эсэх		
3.	Төр хувийн хэвшлийн түншлэл олгох уралдаант шалгаруулалтын журмаар хуулийн дагуу сонгон шалгаруулсан эсэх <i>/Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/</i>		
4.	Түншлэлийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан гол нөхцөл бүрэн тусгагдсан эсэх		
5.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл бүрдсэн эсэх		
6.	Энэ журмын 13.4-т тусгагдсан баримт бичгийг бүрэн ирүүлсэн эсэх		
7.	Ажлын гүйцэтгэл болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх болон санхүүжих дүнг тусгасан эсэх		
8.	Хөндлөнгийн аудитын дүгнэлттэй эсэх		
9.	Гэрээ дүгнэсэн протокол, дүгнэлттэй эсэх		
10.	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх		
11.	Төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлсэн барилга, байгууламжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгах тухай баримт бичигтэй эсэх		
12.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн улсын комиссын акттай эсэх		

Тайлбар:

“Тийм/Үгүй” гэсэн баганад “Тийм”, эсхүл “Үгүй” гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.

ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДАН ГЭРЭЭ
БАЙГУУЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр, Гарын үсэг/

ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН
ГЭРЭЭ БАЙГУУЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:...../Нэр,
Гарын үсэг/

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН
ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:...../Нэр, Гарын үсэг

ОГНОО